

## МОНГОЛ УЛС ЦӨМИЙН ЗЭВСЭГГҮЙ СТАТУСТАЙ БАЙХЫН АЧ ХОЛБОГДОЛ

С.Баясгалан\*

**1** 960-аад оны сүүлээр Зөвлөлт-Хятадын харилцаа муудсан нь Монгол-Хятадын харилцаанд муугаар нөлөөлсөн. Зөрчилтэй харилцаатай байсан хоёр их гүрний дунд орших Монгол улсын хувьд Зөвлөлтийн аюулгүй байдлын хүрээнд байсан учраас Зөвлөлтийг дагаж, Хятадтай харилцаагаа муутгахад хүрсэн байдаг. Тухайн үеийн нөхцөл байдлаас үүдэн Монгол улс ЗХУ-тай 1966 онд Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээ байгуулсан байсан ба энэхүү гэрээний хүрээнд Монгол улсын аюулгүй байдлыг ЗХУ хамгаалж байв. Ингээд Монгол-Хятадын харилцаа нь Зөвлөлт-Хятадын харилцаа сайжрах хүртэл дайсагнасан хэвээр байв<sup>1</sup>.

Энэ үед хоёр их гүрний хооронд цөмийн дайны аюул нүүрлээд байсан ба нутаг дэвсгэртээ Зөвлөлтийн цэрэг, пуужингуудтай Зөвлөлтийн дагуул улсын хувьд Оросын галын шугаманд аюултай байдалд байсан туршлага юм<sup>2</sup>. Чухамдаа Монгол улс өөрийгөө цөмийн зэвсэггүй болгон зарлах гол хүчин зүйлийн түүхэн сургамжийн нэг нь Зөвлөлт-Хятадын зөрчилдөөн гэж үзэж болно.

Хүйтэн дайн дуусч ЗХУ задарснаар Монгол улсын гадаад орчин нөхцөл ч өөрчлөгдөж урьд нь дайсагнасан харилцаатай байсан Монгол-Хятадын харилцаа аажмаар зөөлөрч хэвийн байдалд орсон. Энэ нь нөгөө талаар ЗХУ, БНХАУ-ын хооронд тохиролцсон хоёр орны харилцааг сайжруулах гурван саадын нэг болох Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргасны дараа болов.

Гэвч олон улсын харилцаанд гарч буй эргэлт буцалтгүй огцом өөрчлөлт Монголын гадаад орчинд ч илэрч эхлэв. Энэ нь өмнө нь ЗХУ-ын аюулгүй байдлын баталгаан дор байсан Монгол улсын хувьд үүсээд буй нөхцөл байдлаа нухацтай эргэн харах шаардлагыг бий болгов. Монгол улсын хувьд гадаад орчны энэхүү өөрчлөлт шинэ шинэ сорилтуудыг бий болгож байв. Эдгээр сорилтуудын хамгийн эхнийх нь Монгол улсын газар зүйн байршилаас шалтгаалан аюулгүй байдлаа бэхжүүлэх, ашиг сонирхолоо олон улсын тавцан дээр хамгаалах хэрэгтэй болов.

\* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

1. Migidorj Batchimeg, *Future Challenges for the PRC and Mongolia: a Mongolian Perspective*, China Brief Volume: 5 Issue: 10, [http://www.jamestown.org/single/?no\\_cache=1&tx\\_ttnews%5Btt\\_news%5D=3853](http://www.jamestown.org/single/?no_cache=1&tx_ttnews%5Btt_news%5D=3853)

2. Susan Y. Lawrence, *Mongolia: Issues for Congress*, Congressional Research Service, June 14, 2011, p 13, <http://www.fas.org/sgp/crs/row/R41867.pdf>

1990 оноос өмнө манай улсад ЗХУ-ын цэрэг байрлаж Монгол улсын тусгаар тогтнолыг хамгаалах баталгаа болж байв. Харин ЗХУ-ын цэрэг Монголоос гарсны дараа Монгол улс цаашид үндэсний аюулгүй байдлаа ямар арга замаар, хэрхэн хангах вэ гэсэн асуудал гарч ирсэн. Түүхээ эргэн сөхөвөөс бид хоёр хөршийн дунд байхдаа тэдгээрийн буфер<sup>3</sup> болж байсан нь Монголд Оросын болон Хятадын цэрэг орж ирж байснаас харж болно. Иймээс бид аюулгүй байдлаа хангахын тулд 1990 оны 1 сард батлагдсан Үндсэн хуулийн 4.3-т “хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно”, мөн 11.2-т “Монгол улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна...” гэж заасан байдаг, мөн цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэнтэй хиллэдэг учраас 10.1-т “Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, 10.2-т “Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж тус тус заасан байдаг.

Зөвлөлтийн цэрэг Монголоос гарсны дараа, 1992 оны 9 сарын 25-нд болсон НҮБ-ын Ерөнхий ассамблейн 45-р чуулган дээр Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болсныг зарласан. Монгол улсын энэхүү алхам нь 1968 оны Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ, 1974 оны 12 сарын 9-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 3261 F тогтоолд нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс байж болох талаар заасныг үндэс болгосон байдаг. Уг тогтоолд “ЦЗБ байгуулахтай холбогдсон үүрэг бүлэг улсууд, түүн дотроо газар зүйн том бүс нутгууд, нэг тивийг төдийгүй цөөн тооны улсууд тэр ч бүү хэл НЭГ УЛС ч байж болно” гэсэн заалт байдаг. Монгол улс өөрийн аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хамгаалж байсан төдийгүй, өөрийн энэхүү бие даасан алхмаараа нээлттэй гадаад бодлого явуулж чаддагаа харуулсан юм. Тухайн үед ЗХУ задран унаснаар олон улсын нөхцөл байдал маш хурдацтай өрнөж байсан учраас их гүрнүүд Монгол улсын мэдэгдэлд ямар нэгэн мэдэгдэл хийлгүй чимээгүй өнгөрсөн юм.

Зөвлөлтийн цэрэг Монгол улсаас гарснаар монголчууд аюулгүй байдлын асуудлаа өөрсдөө шийдэж, хараат бус, бие даасан гадаад бодлого явуулах шаардлагатай болсон билээ. Ингээд 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалдаа гадаад бодлогын гол чиг шугамаа гаргахдаа “Монгол улсын үндэсний ашиг сонирхлыг шууд хөндөөгүй хөрш хоёр орныхоо маргаанд хөндлөнгөөс үл оролцоно. Цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй, гадаадын цэрэг, зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад

3. Батлан хамгаалахын өнцгөөс авч үзвэл ЗХУ-ыг Хятадын аливаа дайралтаас хамгаалах хэсэг орон зай болж байна

зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтална” гэж заасан байдаг ба хүйтэн дайны үеийн туршлагаасаа сургамж авч үүнийг “...аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилж, гадаад орнууд дахь Монголын сонирхлыг улс төр-эрх зүйн аргаар бататган хамгаална”<sup>4</sup>, мөн “Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулах, аюулгүй байдлаа улстөрийн аргаар бэхжүүлэх чухал тулгуур болгох явдал”<sup>5</sup> гэж заасны дагуу олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, дэлхийн улс орнуудтай дипломат харилцаа тогтоож, олон улсын байгууллагад гишүүнээр элсэн орох замаар улс төр, эрх зүйн аргаар өөрийн бүрэн бүтэн, аюулгүй байдлаа батлан хамгаалах аргыг Монгол улс сонгон авсан юм.

1992 онд Монгол улс цөмийн зэвсэггүй бүс (ЦЗБ) болсноо зарласан талаар хоёр хөршөөс гадна НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн цөмийн зэвсэгтэй бусад гүрнүүд ч мэдэгдэл гаргаагүй чимээгүй өнгөрсөн билээ. 1992 онд Монгол улсын нутаг дэвсгэр дээр цөмийн зэвсэг үйлдвэрлэх, боловсруулах, эзэмших, хянах, байрлуулах, тээвэрлэх, турших, хэрэглэхийг хориглосон Монгол улсын цөмийн зэвсэггүй статусын тухай хууль батлагдаж 2000 онд хүчин төгөлдөр болсон билээ<sup>6</sup>. Монгол улсын энэхүү тунхаглал нь магадгүй дэлхийд цөмийн зэвсэг хийхэд нэн чухал түүхий эд болох, магадгүй түүнийг цөмийн зэвсэг хийхэд ашиглаж болох ураны нөөц ихтэй улс цөмийн зэвсгийг хориглож байгаа дохио болсон юм<sup>7</sup>. Хоёр хөршөөрөө өөрийн статусаа бэхжүүлэхийн тулд Монгол улсын авч хэрэгжүүлсэн дараагийн чухал алхам нь 1993 оны 1 сарын 20-нд байгуулсан Монгол улс Оросын Холбооны улсын хооронд байгуулсан Найрсаг харилцаа, Хамтын ажиллагааны тухай гэрээний 4-р зүйлд: “Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол улсын бодлогыг ОХУ хүндэтгэнэ” гэсэн заалтыг оруулсан явдал байв. Үүний дараа нь буюу 1993 оны 10 дугаар сарын 12-нд БНХАУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчийн хийсэн мэдэгдэлд: “БНХАУ Монгол улсыг цөмийн зэвсэггүй улс хэмээн сайшаан дэмждэг бөгөөд газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс болгох бодлогыг нь хүндэтгэнэ. БНХАУ урьд нь цөмийн зэвсэггүй бүс, улсуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй, хэрэглэхээр заналхийлахгүй хэмээн амлаж байсан. Уг амлалт Монгол улсыг ч мөн адил хамаарна.”<sup>8</sup> хэмээжээ.

4. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал 1994

5. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 1994

6. Susan Y. Lawrence, Mongolia: Issues for Congress, Congressional Research Service, June 14, 2011, p 12, <http://www.fas.org/sgp/crs/row/R41867.pdf>

7. Susan Y. Lawrence, Mongolia: Issues for Congress, Congressional Research Service, June 14, 2011, p 13, <http://www.fas.org/sgp/crs/row/R41867.pdf>

8. Т.Ариунсанаа. “Монгол улсын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статус”, УБ., 2001, 30-31-р тал

Хоёр хөрш ийм мэдэгдэл хийсний дараа АНУ Монгол руу анхаарлаа хандуулж мөн оны 10 сард АНУ-ын Монгол дахь ЭСЯ, Төрийн Департаментас гаргасан мэдэгдэлд: “Монгол улсын Засгийн газар Монгол, АНУ хоёрын нэгдэн орсон Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай 1968 оны гэрээний зарчмыг тууштай дэмждэг ба Монгол улсыг цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан шийдвэрийг нь АНУ-ын Засгийн газар сайшаан үздэг гэсэн мэдэгдэл гаргав. Гурван гүрэн Монгол улсын ЦЗБ-ийн бодлогыг хүндэтгэн үзэж буй талаарх мэдэгдэл гаргасан нь Монгол улсын хувьд том алхам болсон. Учир нь өнөөг хүртэл цөмийн зэвсэгтэй гүрнүүд нэг улс өөрийгөө ЦЗБ болгон зарлах асуудалд дургүйцэж, хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Иймээс Монгол улс энэхүү алхамаа цаашид ч бэхжүүлэх арга хэмжээ авч байна.

АНУ-ын байр суурийг ажиглаж байсан Их Британи 1993 оны 11 дүгээр сарын 1-нд дараах мэдэгдэл хийжээ. Үүнд: “Эрхэмсэг Хатан Хааны Засгийн газар Монгол улсын Засгийн Үл дэлгэрүүлэх гэрээний зарчмыг дэмжиж буйгаа дахин нотлон, газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан шийдвэрийг сайшааж байна. Үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч, цөмийн зэвсэггүй улсуудад хандан гаргасан: цөмийн зэвсэг хэрэглэгсэн түрэмгийллийн хохирогч буюу заналхийллийн объект болсон Үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч улсад НҮБ-ын дүрмийн дагуу нэн даруй Аюулгүйн Зөвлөлийн тусламж үзүүлэх тухай нэгдсэн Вант улсын олгосон аюулгүйн баталгааг Монгол улс хүртэнэ. Нэгдсэн Вант улс, түүний харьяа газар нутаг, зэвсэгт хүчнийг цөмийн зэвсэгтэй улстай холбоотны харилцаатай буюу сүлбэлдсэн улс довтолсноос бусад тохиолдолд Монгол улс болон Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч цөмийн зэвсэггүй бүх улс, олон улсын бусад тохиролцоогоор цөмийн тэсрэх төхөөрөмж бүтээхгүй, олж авахгүй гэсэн үүрэг хүлээсэн улсуудын эсрэг, Нэгдсэн Вант улс цөмийн зэвсэг хэрэглэхгүй гэдгээ дахин амлаж байна.”<sup>9</sup>

Үүний дараа 1994 оны 1 сард Францын Гадаад Хэргийн Яам дараах мэдэгдлийг хийсэн. “Бүгд Найрамдах Франц улс Үл дэлгэрүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ дахин нотлон газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан Монгол улсын Засгийн газрын шийдвэрийг сайшаан хүлээн авч байна. Франц буюу түүнтэй аюулгүй байдлын харилцаатай улсын эсрэг цөмийн зэвсэгтэй улстай холбоотны харилцаатай буюу сүлбээтэйгээр түрэмгийлэх үйл ажиллагаа үйлдсэнээс бусад тохиолдолд цөмийн зэвсэггүй, мөн цөмийн зэвсэгтэй болохгүй гэдгээ амласан улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй гэсэн өмнөх мэдэгдлээ Монгол улсын хувьд дахин нотолж байна. Үл дэлгэрүүлэх гэрээг тодорхойгүй хугацаагаар, нөхцөл тавилгүй сунгахыг дэмждэг Франц улс Монгол улсын нэгэн адил

9. Т.Ариунсанаа Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус.УБ.,2001 он, 32-33-р тал

байр суурийг нааштайгаар хүлээн авлаа.”<sup>10</sup>

1994 оны 3 сарын 1-нд ОХУ-ын Гадаад Хэргийн Яамны төлөөлөгчийн хийсэн мэдэгдэлд: “1992 онд Монгол улс өөрийгөө цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан билээ. АНУ, БНХАУ, Умард Ирландын Нэгдсэн Вант улсууд, саяхан Франц улс Монгол улсын энэхүү статусыг хүндэтгэх тухай амласан мэдэгдэл хийлээ. Орос улс, цөмийн бусад гүрнүүдийн нэгэн адилаар, Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэх болно. 1993 оны 1 сарын 20-нд Монгол улстай байгуулсан Найрсаг харилцаа, Хамтын Ажиллагааны тухай гэрээнд Орос улсын байр суурь тусгагдсаныг дурдах нь зүйтэй. Уг гэрээний 4 дүгээр зүйлд: Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол улсын бодлогыг ОХУ хүндэтгэнэ” хэмээн өгүүлсэн байна<sup>11</sup>.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монголд айлчлах үеэр гаргасан 2000 оны 11 сарын 14-ний хамтарсан Улаанбаатарын тунхаглалд “Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан тус улсын аюулгүй байдлын баталгааны талаар цөмийн зэвсэгтэй таван гүрний хамтран гаргасан мэдэгдлийн үзэл санааг Орос улс тууштай сахин баримтлахаа нотлож байна.<sup>12</sup>”

Монгол улсын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статусын талаарх НҮБ-ын ЕА-ын тогтоолыг хэрэгжүүлэх асуудал дээр Хятад улс Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэн үзэх байр суурьтай байгаагаа илэрхийлсэн ба Монгол улсын энэхүү статуст цөмийн зэвсэгтэй таван гүрэн хамтран аюулгүйн баталгаа гаргасан.

Монгол улсын цөмийн зэвсэггүй статусын талаар Хятад улс хэд хэдэн мэдэгдлүүдийг хийж, өөрийн байр сууриа илэрхийлсэн байдаг.

1994 оны 4 сарын 29-нд Монгол Хятадын хэвлэлийн хамтарсан мэдэгдэлд: “Хятадын тал Монгол улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статусыг хүндэтгэж байгаагаа дахин нотлов. Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, түүнийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол улсын бодлогыг БНХАУ хүндэтгэн үзэж байгаагаа илэрхийлэв”<sup>13</sup> хэмээн дурьджээ.

10. Ариунсанаа Т. Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус. УБ., 2001 он, 28-29-р тал

11. Т.Ариунсанаа. “Монгол улсын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статус”, УБ., 2001, 34-р тал

12. Монгол-Оросын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл. УБ.2006

13. Монгол улс БНХАУ-ын Найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ, 1994

1994 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэнд НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн улс орнуудын хувьд аюулгүйн зөвлөлөөс мэдэгдэл гаргаж өгөөч гэсэн асуудал тавьсан. Үүнтэй холбогдуулан, 1995 онд Үл дэлгэрүүлэх гэрээг тодорхойгүй хугацаагаар сунгахыг дэмжихээр шийдвэрлэснийг нь сайшааж байна. АНУ-тай найрсаг харилцаатай, Үл дэлгэрүүлэх гэрээний шийдвэр зоригийг дэмждэг Монгол улс нь цөмийн зэвсэггүй улсын хувьд, ҮДГ-ний оролцогч цөмийн зэвсэггүй улсууд цөмийн довтолгоонд өртсөн үед Аюулгүйн Зөвлөлийн тусламжийг хүртэхэд туслах болон, цөмийн зэвсэгтэй улстай холбоотон бус цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй тухай АНУ-ын баталгааг хүртэнэ. Цөмийн зэвсэгтэй бусад улсууд мөн үүнтэй ижил баталгаа гаргасан. Хэрвээ Монгол улс аюул заналтай тулгаран, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн бусад улсын хамтаар, зохих алхам хийгдэх ёстой гэж үзнэ”<sup>14</sup> гэжээ.

1998 онд НҮБ-ын ЕА-аас А/RES/53/77 “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статус” хэмээх Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих тухай тогтоол гаргасан юм. Уг тогтоолд “Монгол Улс газарзүйн хувьд өвөрмөц байрлалтай, далайд гарцгүй орон. Тиймээс нутаг дэвсгэрийнх нь бүрэн бүтэн, хил хязгаарын халдашгүй дархан, эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал их чухал тул цөмийн зэвсэггүй статусыг нь дэмжиж байна” гэж дурьдсан байдаг. НҮБ-ын ЕА Монголын бодлого, санаачилгыг дэмжин хүлээн авч гишүүн бүх улс орнуудыг ЦЗБ байгуулах, түүний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллахыг уриалсан. Ингэснээр НҮБ-ын ЕА “тус бүс нутаг дахь энхийн, нөхөрсөг, харилцан ашигтай харилцааг хөгжүүлэхэд оруулж буй Монгол улсын идэвхтэй, эерэг оролцоог” дэмжиж байгааг цохон тэмдэглэхийн зэрэгцээ энэ нь аюулгүй, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд өндөр хувь нэмэртэй болохыг сайшаан дэмжив.

Цөмийн зэвсэгтэй таван гүрнээс гадна Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөн Монгол улсын ЦЗБ-ийн бодлогыг дэмжсэн. Улс төрийн ийм дэмжлэгийг эрх зүйн үндэстэй болгож бататгахын тулд манай тал сүүлийн жилүүдэд нэлээд чармайлт гаргасан боловч цөмийн зэвсэгтэй гүрнүүд тийм баталгаа өгөхөөс зайлсхийж ирэв<sup>15</sup>. Ийм нөхцөлд Монгол Улсын гадаад аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг батжуулан бэхжүүлэхэд хамтран ажиллахыг НҮБ-ын бүх гишүүн, түүний дотор цөмийн зэвсэгтэй гүрнүүдэд уриалсан тогтоолыг Ерөнхий Ассамблей 1998 онд манай санаачилгыг үндэслэн гаргасан нь чухал үйл явдал болсон<sup>16</sup>.

14. Т.Ариунсанаа Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус.УБ.,2001 он, 28-29-р тал

15. Дүгэрсүрэн, Олон улсын эрх зүй, 263-р тал

16. Дүгэрсүрэн, Олон улсын эрх зүй, 263-р тал

1998 онд НҮБ-ын ЕА Монголын бодлого, санаачилгыг дэмжиж, гишүүн бүх улс орнууд Монголын цөмийн зэвсэггүй бүсийн статус, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллахыг уриалжээ<sup>17</sup>.

1998 оны 12 сарын 4-нд болсон 79-р чуулган болж 1999 оны 1 сарын 12-нд A/RES/53/77 Монголын олон улсын аюулгүй байдал, ЦЗБ-ийн статус<sup>18</sup> 2000 оны 2 сарын 3-нд Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай УИХ-ын 19 тоот тогтоолыг баталсан. Уг хууль нь Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хяналтандаа байлгах, байрлуулах, аливаа хэрэгслээр тээвэрлэх, туршилт хийх, цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхит материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах, устгахыг хориглосон<sup>19</sup>. Монгол улс 2000 онд Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолыг баталж өөрийн статусаа баталгаажуулсан. 2000 оны 2 сарын 29-нд Монгол улсын цөмийн зэвсгээс ангид хуультай танилцсаны дагуу Ерөнхий Ассамблейн 55 дахь чуулганаас A/55/56/S/2000/160 тогтоолыг баталсан байдаг.<sup>20</sup> үүний дараа 10 сарын 17-нд Монгол улсын засгийн газрын мэдэгдлийг A/55/491-S/2000/994-г батлав<sup>21</sup>.

Монгол улс 2000 онд Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулиа баталсан нь үндэсний хэмжээнд хууль зүйн акттай болсон гэдэг утгаараа тухайн үедээ анхдагч байсан юм.

2000 оны 11 сард Японы төлөөлөгч НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулган дээр хэлсэн үгэндээ Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжиж байгаа байр сууриа илэрхийлсэн. 2000 оны 10 сарын 31-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүд “Монгол улсын ЦЗБ-ийн статустай холбоотой аюулгүй байдлын баталгааны талаарх мэдэгдэл” гаргав.<sup>22</sup>

2000 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монголын аюулгүй байдалд эерэг болон сөрөг баталгаа өгч байгаа талаар хамтарсан мэдэгдэл хийсэн<sup>23</sup>. АЗ-ийн байнгын таван гүрний хийсэн улс төрийн тунхаглалыг өргөжүүлэн албан ёсны баримт бичиг болгох талаар асуудал тавьсан<sup>24</sup> ба Монгол улсын

17. Enkhsaikhan.J, Mongolia and Nuclear Age, “China and Eurasia Forum Quarterly”, Yol 5, No 3 (2007), p 26

18. Fifty-fifth session, Single State NWFZ: Progress and Prospects, Blue Banner NGO, UB, 2007, p 12

19. Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль. УБ.2000

20. <http://www.opanal.org/NWFZ/Mongolia>

21. Fifty-fifth session, Single State NWFZ: Progress and Prospects, Blue Banner NGO, UB, 2007, p 23

22. Single State NWFZ: Progress and Prospects, Blue Banner NGO, UB, 2007, p 20

23. Enkhsaikhan.J, Mongolia and Nuclear Age, “China and Eurasia Forum Quarterly”, Yol 5, No 3 (2007), p 26

24. Enkhsaikhan.J, Mongolia and Nuclear Age, “China and Eurasia Forum Quarterly”, Yol 5, No 3 (2007), p 26

баталгааны асуудлыг тусгайлан ярихаар болж 2001 онд Саппород уулзсан. 2001 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол болон НҮБ-ын шинжээчид Саппород уулзаж, манай улсын цөмийн зэвсэггүй статусыг цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргасан.

2001 онд цөмийн зэвсэгтэй ОХУ, АНУ, БНХАУ, Франц, Их Британи гэсэн таван гүрэн уг статусыг дэмжиж, аюулгүй байдлыг хангах хамтын баталгааг гаргах тогтоолд гарын үсэг зурсан.

2002 оны 3 сарын 20-нд 2001 онд Японы Саппоро хотод болсон НҮБ-ын шинжээчдийн бүлгийн уулзалтаас гаргасан зөвлөмжийн дагуу Монгол улс хоёр хөршдөө хандан Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах “Монгол улсын цөмийн зэвсэггүй статусын талаар Монгол улс, БНХАУ, ОХУ-ын хооронд байгуулах Гэрээний үндсэн элементүүд” нэртэй гурван талт гэрээнд тусгаж болох саналуудыг хөрш орнууддаа танилцуулсан билээ.

Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статус Монгол улсын аюулгүй байдлыг улс төр, хууль зүйн талаар баталгаажуулах бодлогод үндэслэнэ<sup>25</sup>. Ийм учраас Монгол их гүрнүүдийн өрсөлдөөнд татагдан орохгүй байх, Монголын бодлогын өөрчлөлт бүс нутаг дахь хүчний тэнцвэрт нөлөөлөөгүй тохиолдолд тус бүс нутгийн тогтвортой ойлгомжтой байдлыг баталгаажуулахад маш чухал юм<sup>26</sup>.

Манай статусыг хүлээн зөвшөөрөхөд улс төрийн суурь болох НҮБ-ын ЕА-аас гаргасан “Монголын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статус” хэмээх 53/77 D тогтоол байдаг. Үүгээр ЕА аюулгүй, тогтвортой байдлыг бий болгож байгаа “Бүс нутгийн улс орнуудтай энх тайванч, найрамдал, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж буй Монголын эерэг, идэвхтэй хувь нэмрийг” талархан дэмжиж байна.

2004 оны 1 сарын 31-ний Монгол улс болон Америкийн Нэгдсэн Улсын Хоёр талт болон бүс нутгийн хамтын ажиллагааны тухай Хамтарсан мэдэгдэл<sup>27</sup> болон 2004 оны 7 сарын 15-нд гаргасан Монгол-Америкийн хамтарсан мэдэгдлээр “Америкийн Нэгдсэн Улс Зүүн Хойд Азид итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээгээр баталгаажуулах тэдний хүчин чармайлтыг сайшаан дэмжиж байна”<sup>28</sup> гэсэн байна.

25. Enkhsaikhan.J, Mongolia and Nuclear Age, “China and Eurasia Forum Quarterly”, Yol 5, No 3 (2007), p 25

26. Enkhsaikhan.J, Mongolia and Nuclear Age, “China and Eurasia Forum Quarterly”, Yol 5, No 3 (2007), p 26

27. [http://www.mongolianembassy.us/mongolia\\_and\\_usa/joint\\_statement\\_on\\_bilateral\\_and\\_regional\\_cooperation.php](http://www.mongolianembassy.us/mongolia_and_usa/joint_statement_on_bilateral_and_regional_cooperation.php)

28. [http://www.mongolianembassy.us/mongolia\\_and\\_usa/joint\\_statement\\_between\\_the\\_us\\_and\\_mongolia.php](http://www.mongolianembassy.us/mongolia_and_usa/joint_statement_between_the_us_and_mongolia.php)



Үүнээс үзэхэд, АНУ Монгол улсын цөмийн зэвсэггүй статуст сөрөг баталгаа өгсөн байдаг. Сөрөг баталгаа гэдэг нь Монгол улсад цөмийн аюул учирсан тохиолдолд НҮБ-ээр хэлэлцүүлэх юм. Гэвч уг статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах асуудлыг дэмжин сайшааж байгаа боловч мөн болгоомжилсон байр суурьтай байгаа. Учир нь Монгол улсын уг статус олон улсын хэмжээнд баталгаажих тохиолдолд АНУ-ын шүхэр дор байдаг Япон, БНСУ зэрэг улсууд дангаараа цөмийн зэвсэггүй бүс байгуулах боломжтой эсэх талын асуулт гарч ирнэ хэмээн болгоомжилдог.

Монгол-БНХАУ-ын 2004 оны 7 сарын 6-ний хамтарсан мэдэгдэлд: "... талууд Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал юм гэж үзэв. Статусаа баталгаажуулах талаар Монгол улсын гаргаж буй хүчин чармайлтыг Хятадын тал дэмжиж байгаагаа илэрхийлсэн"<sup>29</sup> байдаг.

2006 оны 5 сард Өмнөд Солонгосын тал "Цөмийн зэвсгээс ангид байх статусаа олон улсын хэмжээнд баталгаажуулах талаар Монгол улсын тавьж буй хүчин чармайлт нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх горимыг бэхжүүлэх, ЗХА болон бусад бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах чухал арга хэмжээ гэж үзэж, түүнийг БНСУ дэмжиж байгааг"<sup>30</sup> Ерөнхийлөгч Ну Мү Хён илэрхийлжээ.

2006 оны 12 сарын 18-нд А/RES/61/87<sup>31</sup> Өмнө нь өгүүлсэн Хятадын санал хүсэлтийг хүлээн авч гэрээний төсөлдөө тусган боловсруулж, уг төслөө 2007 онд хоёр хөршдөө гардуулсан.

Монгол улсын Ерөнхий Сайд С.Баярыг 2008 онд ОХУ-д айлчлах үеэр гаргасан Монгол-Оросын хамтарсан албан мэдээнд "Цөмийн зэвсэггүй статусаа бэхжүүлэх талаар Монгол улсын тавьж буй хүчин чармайлтыг Орос улс Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний дагуу цөмийн зэвсэггүй орных нь хувьд Монгол улсад олгогдсон, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1995 оны 4 дүгээр сарын 11-ний 984 дүгээр тогтоолоор болон НҮБ-ын АЗ-н байнгын гишүүн-цөмийн таван гүрний 2000 оны 10 дугаар сарын 5-ны хамтарсан мэдэгдэлд тусгагдсан аюулгүй байдлын баталгааг нотлож байна"<sup>32</sup>

2009 оны 8 сарын 25-26-нд Монгол, ОХУ-ын стратегийн түншлэлийн тунхаглалд дэлхий дахинд цөмийн зэвсгээс ангид бүсүүд байгуулах нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бэхжүүлэх чухал арга хэрэгслийн нэг гэдгийг Ерөнхийлөгч нар онцлон тэмдэглэсэн. "Олон

29. "Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн явцын тухай илтгэл" Хавсралт 6. 24-р тал

30. "Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн явцын тухай илтгэл" Хавсралт 6. 2006 оны 5 сарын 10-ний Монгол, БНСУ-ын хамтарсан мэдэгдэл

31. Single State NWFZ: Progress and Prospects, Blue Banner NGO, UB, 2006, p 55

32. Монгол-Оросын хамтарсан албан мэдээ, Москва хот, 2008.04.13

улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь энэ үйл явцад ихээхэн хувь нэмэр оруулж байна” гэж ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев мэдэгджээ<sup>33</sup>.

Ерөнхийдөө ОХУ Монгол улсын уг статусыг хүндэтгэн үзэж байгаа бөгөөд цөмийн таван гүрний гаргасан аюулгүйн баталгааны үзэл санааг тууштай баримталж, 3 талт гэрээ байгуулах асуудал маш нарийн боловсруулах шаардлагатай гэдгийг дурдан, Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулах талаар Монгол улсын санал болгосон гэрээний төслийг дахин авч хэлэлцэх хурал зөвлөлгөөнд оролцож, өөрсдийн санал хүсэлтээ тавьсаар байгаа юм.

2013 оны 9 сарын 26-нд Нью Йорк хотноо болсон НҮБ-ын ЕА-н 68-р чуулганд Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үг хэлэхдээ “Монгол Улс Ерөнхий нарийн бичгийн дарга Цөмийн зэвсгийг хориглох таван зүйлт санаачилга дэвшүүлснийг дэмжиж, цөмийн зэвсгийг хориглох нь хойшлуулалгүй анхаарах шаардлагатай асуудлуудын нэг мөн гэдэгтэй санал нэгдэж байна”<sup>34</sup> гэжээ. Зэвсэг хураах олон талт яриа хэлэлцээний цор ганц чуулган зэвсэг хураах бага хурал санаанд хүрэхгүй байгаа нь тун ч тоогүй. Үйл ажиллагааг нь идэвхжүүлэхэд чиглэсэн зөвлөгөөн явагдаж байгаа ч зэвсэг хураах бага хурал саатсан хэвээр байна. Монгол улсын цөмийн зэвсэггүй бүс “дэлхий ертөнцийг цөмийн зэвсгээс ангижруулах үйлсийн тусын тулд цөмийн зэвсэгтэй хоёр гүрэнтэй хил залган оршдог Монгол Улс 20 жилийн тэртээ нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн дангаараа зарласан бөгөөд энэ статусыг механизм болгохоор шаргуу чармайн ажиллаж байна.” 2012 оны есдүгээр сард цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг хүлээн зөвшөөрсөн төдийгүй хүндэтгэх, түүнийг зөрчих алхам хийхгүй гэдгээ зарлан тунхагласан. Цөмийн зэвсгээс ангид дэлхий ертөнцийг байгуулахад жижиг улс ч өөрийн хувь нэмэр оруулах боломжтойг харуулж чадсанаараа ач холбогдолтой юм.

---

33. <http://www.yip76.mn/busad/3-uil-yaydlyn-medee/6142-mongol-uls-oxu-yn-strategiin-tunshleliin-tunxaglal-.html>

34. <http://www.president.mn/mongolian/node/3567>